



ТӨВ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/145

Зуунмод

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн
бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, 32.1.9, 32.1.10 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд Бүрэн, Лүн, Эрдэнэсант, Алтанбулаг, Өндөрширээт, Заамар, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Баянхангай, Угтаал, Жаргалант, Сүмбэр, Батсүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Архуст, Баянжаргалан (17) суманд зузаан цастайн улмаас цагаан зудын нөхцөл бүрдсэн бол Баянчандмань, Борнуур, Цээл, Баянцогт, Аргалант, Зуунмод, Баянцагаан, Баян, Баяндэлгэр, Мөнгөнморьт (10) сумдын нутгаар цагаанаар удархуу байдалтай байна. Аймгийн нийт сумдад их цасны улмаас малын бэлчээрлэлт хүндэрч, цасан бүрхүүл тогтож малчид, малчдын бэлтгэсэн өвс тэжээлийн нөөц дуусаж, зудын гамшгийг даван туулах, хариу арга хэмжээг зохион байгуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж байгаа тул 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Шуурхай штабын үйл ажиллагааг 24 цагаар тасралтгүй зохион байгуулж, төрийн байгууллагуудын харилцан уялдаа холбоог ханган ажиллахыг Шуурхай штабын дарга (Г.Сурмаа)-д үүрэг болгосугай.

3.Дараах үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллахыг хэлтэс агентлагийн дарга нарт даалгасугай.

3.1.Аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээл, шатахуун түлш, яаралтай түргэн тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний нөөцийг нөхөн бүрдүүлэлт хийж бэлэн байдлыг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Гантулга), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), сумдын Засаг дарга нарт;

3.2.Бусад аймаг, сумдын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийж байгаа малчдад төрийн бүх төрлийн үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэж ажиллахыг, Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Нарантуяа),

Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газрын дарга (М.Буянхишиг), сумдын Засаг дарга нарт;

3.3.Хорогдсон малын сэг зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, вакцины нөөцийг яаралтай бүрдүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн газар (Б.Болдбаатар)-т;

3.4.Цаг агаарын болон шар усны үерийн мэдээ, сэрэмжлүүлгийг иргэд олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуурхай тогтмол хүргэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Г.Эрдэнэбат), Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Э.Гэрэлцогт), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал) нарт;

3.5.Цахилгаан эрчим хүчний гэнэтийн аваар саатал гарсан үед 1, 2 зэрэглэлийн хэрэглэгч нарыг цахилгаан эрчим хүчээр хангаж, аваар саатлыг богино хугацаанд арилгаж, хэвийн горимд оруулж ажиллахыг УБЦТСүлжээ ТӨХК (Л.Гансүх)-д;

3.6.Байгаль, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, ослын улмаас автозам, хаагдсан тохиолдолд зам давааг чөлөөлөх, зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Баянмөнх), Автотээврийн төв (Н.Аасүрэн) нарт;

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, аймгийн Шуурхай штабын дарга (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР